БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/133/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2022 он


Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .......... 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.......... 4
3. Аудитын тайлан .......... 5
3.1 Ерөнхий зүйл .......... 5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.......... 5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 6
3.4 Материаллаг байдал .......... 6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.......... 8
3.8 Аудитын гол асуудал .......... 8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.......... 9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.......... 9
4. Аудитын илрүүлэлт.......... 9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .......... 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2022.02.23 № 33.

танай ______-ны №______т

СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БҮРЭНТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:/bichighereg/2022A4toot

006020659

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,697,848.55** | **13,425,463.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,155,019.70 | 13,425,463.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 678,900.00 | 396,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,476,119.70 | 13,028,563.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 299,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,476,119.70 | 12,729,363.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **299,274,021.29** | **319,722,690.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 299,274,021.29 | 319,722,690.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 288,823,869.62 | 309,388,333.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 236,311,280.00 | 236,311,280.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (18,322,230.48) | (27,483,345.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 163,063,050.00 | 183,972,920.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (93,918,152.87) | (97,898,114.71) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,194,103.00 | 28,102,583.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,504,180.03) | (13,616,989.17) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,450,151.67 | 10,334,356.71 |
| 39301 | Программ хангамж | 503,180.00 | 503,180.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (79,128.33) | (194,923.29) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,026,100.00 | 10,026,100.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **314,971,869.84** | **333,148,153.11** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **313,701,336.84** | **333,148,153.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 313,701,336.84 | 333,148,153.11 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 130,294,986.00 | 130,294,986.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 130,294,986.00 | 130,294,986.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (50,811,602.50) | (31,364,786.23) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (50,811,602.50) | (50,811,602.50) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 19,446,816.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 234,217,953.34 | 234,217,953.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **314,971,869.84** | **333,148,153.11** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **275,888,960.00** | **288,664,790.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **59,755,760.00** | **38,537,990.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 59,755,760.00 | 38,537,990.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 57,730,760.00 | 38,537,990.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,279,560.00 | 37,654,140.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,451,200.00 | 883,850.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **216,133,200.00** | **250,126,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 211,533,200.00 | 245,126,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 211,533,200.00 | 245,126,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,600,000.00 | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 5,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **247,626,291.01** | **268,052,123.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **247,626,291.01** | **268,052,123.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 240,977,055.53 | 259,117,827.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 143,922,137.31 | 152,330,451.00 |
| 210101 | Үндсэн цалин | 98,370,875.27 | 113,628,719.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,530,358.04 | 34,434,532.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,020,904.00 | 4,267,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,073,137.36 | 20,479,635.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,391,065.71 | 14,530,223.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,413,827.74 | 1,285,213.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,131,060.32 | 1,336,013.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 261,559.99 | 302,566.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,875,623.60 | 3,025,619.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,362,846.00 | 16,475,044.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 498,296.00 | 777,044.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,210,480.00 | 15,210,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,654,070.00 | 487,520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,381,946.00 | 10,169,733.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,218,100.00 | 1,661,780.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,200,000.00 | 3,380,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,084,036.00 | 1,968,147.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 211,700.00 | 468,450.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 802,650.00 | 510,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,865,460.00 | 2,180,456.70 |
| **2105** | **Норматив зардал** | 951,800.00 | 741,930.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 951,800.00 | 741,930.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,462,793.00 | 3,696,520.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,840,720.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 101,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,462,793.00 | 754,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,972,800.00 | 6,752,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,972,800.00 | 6,752,500.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 360,055.00 | 307,792.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 114,000.00 | 114,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,390.00 | 15,392.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 12,000.00 | 58,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,489,540.86 | 48,164,221.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,909,700.00 | 10,876,060.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,394,000.00 | 5,326,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,185,840.86 | 31,961,811.18 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,649,235.48 | 8,934,296.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,600,000.00 | 4,880,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,600,000.00 | 4,880,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,049,235.48 | 4,054,296.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,049,235.48 | 4,054,296.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **28,262,668.99** | **20,612,666.27** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 772,300.00 | 1,165,850.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 772,300.00 | 1,165,850.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (772,300.00) | (1,165,850.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **27,490,368.99** | **19,446,816.27** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 130,294,986.00 | 234,217,953.34 | (77,301,971.49) | | 287,210,967.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **130,294,986.00** | **234,217,953.34** | **(77,301,971.49)** | - | 287,210,967.85 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 26,490,368.99 | | 26,490,368.99 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **130,294,986.00** | **234,217,953.34** | **(50,811,602.50)** | - | 313,701,336.84 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **130,294,986.00** | **234,217,953.34** | **(50,811,602.50)** | - | 313,701,336.84 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **130,294,986.00** | **234,217,953.34** | **(50,811,602.50)** | - | 313,701,336.84 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 19,446,816.27 | | 19,446,816.27 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **130,294,986.00** | **234,217,953.34** | **(31,364,786.23)** | - | 333,148,153.11 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **272,412,760.00** | **287,780,940.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,279,560.00** | **37,654,140.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 56,279,560.00 | 37,654,140.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 56,279,560.00 | 37,654,140.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,279,560.00 | 37,654,140.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **216,133,200.00** | **250,126,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 211,533,200.00 | 245,126,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 211,533,200.00 | 245,126,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,600,000.00 | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,600,000.00 | 5,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **224,669,460.00** | **259,641,940.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **224,669,460.00** | **259,641,940.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **218,020,224.52** | **230,436,164.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 143,922,137.31 | 152,330,451.00 |
| 210101 | Үндсэн цалин | 98,370,875.27 | 113,628,719.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,530,358.04 | 34,434,532.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,020,904.00 | 4,267,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,345,433.21 | 20,207,340.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,663,361.56 | 14,543,540.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,413,827.74 | 1,415,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,131,060.32 | 1,132,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 261,559.99 | 283,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,875,623.60 | 2,831,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,105,520.00 | 16,475,044.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 498,296.00 | 777,044.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,953,154.00 | 15,210,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,654,070.00 | 487,520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,835,986.00 | 7,674,587.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,600,000.00 | 1,238,380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,200,000.00 | 3,380,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,084,036.00 | 1,968,147.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 333,150.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,618,800.00 | 808,060.00 |
| **2105** | **Норматив зардал** | 1,999,700.00 | 839,980.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 999,700.00 | 839,980.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,434,793.00 | 4,929,520.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,000.00 | 3,699,220.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 330,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,599,793.00 | 900,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,972,800.00 | 6,752,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,972,800.00 | 6,752,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,182,155.00 | 1,027,392.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 114,000.00 | 114,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,390.00 | 15,392.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 384,000.00 | 778,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,221,700.00 | 20,199,350.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,581,600.00 | 14,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,640,100.00 | 6,199,350.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,649,235.48** | **29,205,776.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,600,000.00 | 4,880,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,600,000.00 | 4,880,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 20,271,480.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | 12,162,888.00 |
| 213304 | Хөрөнгийн | | 8,108,592.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,049,235.48 | 4,054,296.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,049,235.48 | 4,054,296.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **47,743,300.00** | **28,139,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **43,693,300.00** | **52,410,480.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **43,693,300.00** | **52,410,480.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 43,693,300.00 | 52,410,480.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 43,693,300.00 | 52,410,480.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(42,693,300.00)** | **(52,410,480.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 5,050,000.00 | (24,271,480.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 4,000,000.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 280126800.00 | 278726644.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 280126800.00 | 226316164.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 279646800.00 | 225836164.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 152706500.00 | 152330451.00 |
| 210101 | Үндсэн цалин | 109154500.00 | 113628719.00 |
| 210102 | Нэмэгдэл | 39394000.00 | 34434532.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4158000.00 | 4267200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20579300.00 | 20207340.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14915500.00 | 14543540.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1415900.00 | 1415900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1132800.00 | 1132800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 283200.00 | 283200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2831900.00 | 2831900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17068400.00 | 16475044.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 434700.00 | 777044.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15768400.00 | 15210480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 865300.00 | 487520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7674600.00 | 7674587.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1319600.00 | 1238380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3380000.00 | 3380000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,815,000.00 | 1,968,147.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 280,000.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 880,000.00 | 808,060.00 |
| **2105** | **Норматив зардал** | 840,000.00 | 839,980.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 840,000.00 | 839,980.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 57,340,000.00 | 4,929,520.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 55,000,000.00 | 3,699,220.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,440,000.00 | 330,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 900,000.00 | 900,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,760,000.00 | 6,752,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,760,000.00 | 6,752,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,078,000.00 | 1,027,392.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 114,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 120,000.00 | 120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 20,000.00 | 15,392.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 778,000.00 | 778,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,600,000.00 | 15,599,350.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,000,000.00 | 14,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,600,000.00 | 1,599,350.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 480,000.00 | 480,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 480,000.00 | 480,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.00 | 480,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **52,410,480.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 52,410,480.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 52,410,480.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 280,126,800.00 | 282,780,940.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 245,126,800.00 | 245,126,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 245,126,800.00 | 245,126,800.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 35,000,000.00 | 37,654,140.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000,000.00 | 37,654,140.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,000,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван аудит ХХК-ий Орхон аймаг дахь салбарын ахлах аудитор Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь “Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг хангахад стандартчилал , хэмжил зүйн бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх
- Хэмжил зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хангах
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.8, Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах
- Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тасралтгүй явуулах
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах
- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах
- Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх
- Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах

- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 9,334.9 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 622,326.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,334.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,534.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18176,3 мянган төгрөгөөр буюу 5,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4,000.0 | 0.0 | (4,000.0) |
| Авлага | 1,542.8 | | (1,542.8) |
| Бараа материал | 10,155.0 | 13,425.5 | 3,270.5 |
| Үндсэн хөрөнгө | 299,274.0 | 319,722.7 | 20,448.7 |
| **Нийт хөрөнгө** | **314,971.9** | **333,148.2** | **23,719.2** |
| Өр төлбөр | 1,270.5 | 0.0 | (1,270.5) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 313,769.8 | 333,148.2 | 19,378.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **314,971.9** | **333,148,2** | **18,176.3** |

Бараа материалын данс 13425,5 мянган төгрөг болж 3270,5 мянган төгрөгөөр өссөн нь хөдөлмөр хамгааллын зардал, бараа үйлчилгээний зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлаас худалдан авсан хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, самбар болон тусгай зориулалтын материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 319722,7 мянган төгрөг болж 20448,7 мянган төгрөгөөр өссөн нь хэмжил зүйн эталон тоног төхөөрөмж багаж хэрэгсэл худалдан авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 333,148.2 мянган төгрөг болж 19,378.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 12,775.8 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар, нийт зардал өмнөх оноос 20425,8 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 360,620.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 360,620.9 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 91,786.1 мянган төгрөгөөр бууруулан 268834.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 11,292.0 мянган төгрөгөөр өсгөж, 280,126.8 мянган төгрөгөөр баталжээ. Цалингийн зардал хүрэлцэхгүй байсныг өсгөн тодотгол хийсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 245,126.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 37,654.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 282,780.9 мянган төгрөгийг зарцуулж, 4,054.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 282,780.9 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 376.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 372.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 593.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 58.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5,000.0 мянган төгрөгийн сургалтын зардлын санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 4600.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлын данснаас сургалтын үйл ажиллагаанд, 400.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Бараа материалын дансанд хангамжийн материал, аж ахуйн материал, хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэрэг бүх төрлийн материалыг нэг дансанд бүртгэж тайлагнадаг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралт болон байгууллагын бодлогын баримт бичигт заасан бараа материалын дансны ангиллын дагуу бараа материалыг ангилан бүртгэж байх, Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших. Мөн Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй 1 800.0 мянган төгрөгийн гарын бэлэг, шагнал урамшууллын мөнгө олгосон "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6, 1.3 дахь заалтын хүрээнд зардал гаргахгүй байх заалтыг зөрчсөн байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2021 онд нийт 280126,8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 280126.8 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших, "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим аргын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4,374.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 4000.0 | 1 | 4000.0 | | | |
| Зөвлөмж | 4 | 4374.3 | 4 | 4374.3 | | | |
| Нийт дүн | 5 | 8374.3 | 5 | 8374.3 | | | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,042.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 220.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3022.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### 4.3 Албан шаардлага

Тайлант оны батлагдсан төсвөөс үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зарим зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт үүсгэхээр тооцож зарцуулах байсан хэдий ч хэмнэлт үүсгээгүй, төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй 1,800.0 мянган

төгрөгийн гарын бэлэг, шагнал урамшууллын мөнгө олгосон тул 2 албан шаардлага хүргүүлэв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бараа материалын дансанд хангамжийн материал, аж ахуйн материал, хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэрэг бүх төрлийн материалыг нэг дансанд бүртгэж тайлагнаж байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2-р хавсралт болон байгууллагын бодлогын баримт бичигт заасан бараа материалын дансны ангиллын дагуу бараа материалыг ангилан бүртгэж байх шалгуурт нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Бараа материалын дансанд хангамжийн материал, аж ахуйн материал, хүнс, тусгай зориулалтын материал, эм бэлдмэл зэрэг материалыг тус бүрийн дансанд салгаж бүртгэх .

***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Өөрийн орлогыг нярвын хувийн дансаар авч шимтгэлээр орлогыг дутуу тайлагнаж байна. Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу орлогыг бүрэн бүртгэх шалгуурт нийцэхгүй байна

*2.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Үндсэн үйл ажиллагааны орлогыг Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу орлогыг бүрэн бүртгэж тайлагнах.

***3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бодлогын баримт бичгийн дансны төлөвлөгөөний дагуу зардлыг тайлагнаагүй нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 1 313.0 мянган төгрөгийн хүлээн авалтын хоол хүнсний материалыг, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1 700.0 мянган төгрөгийн хоолны материалыг зарлагадаж тайлагнасан байна. "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6, 1.3 дахь заалтын хүрээнд зардал гаргахгүй байх заалтыг зөрчсөн байна.

*3.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Бодлогын баримт бичгийн дансны төлөвлөгөөний дагуу "Төсвийн тухай" хуулийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6, 1.3 дахь заалтын хүрээнд зардлыг гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 6 | 5,042.7 | | | 1 | 220.0 | 2 | 1800.0 | 3 | 3022.7 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР